

## **Монгол хэл бичгийн мэдээлэл боловсруулалтад зориулсан тэмдэг нэрийн утгын ангиллын тогтолцоо**

Хай Ин Хуа  
(Өвөр Монголын Их Сургууль)

**Abstract:** In Mongolian, nouns, adjectives and verbs are three Open Part of Speech, which occupy a relatively high proportion in the vocabulary of the dictionary and corpus. Therefore, the semantic classification of it is not only the component of Mongolian lexical semantics but also the basic content of Mongolian computational semantics. For the Mongolian corpus processing and semantic dictionary development needs, using the semantic field theory as the framework, the project divided 6 major categories, 262 sub-categories on the lexical basic meaning of the adjectives, and developed its corresponding mark set, completed the semantic annotation on "one million-word modern Mongolian corpus". The paper dissertates the Theory of Semantic Field based on the overview of previous research of Mongolian semantics, and describes the semantic classification and its mark set, and the application in corpus processing.

**Keywords:** Mongolian adjectives, semantic classification system, mark set

**Товч утга:** Тэмдэг нэр, жинхэнэ нэр, үйл үг нь монгол хэлний гурван том “задгай шинжтэй” үгсийн аймаг (Open Part of Speech) бөгөөд толь бичиг, хэлний материалын хөмрөг зэрэгт эдгээр үгсийн аймгийн эзлэх хувь нь харьцангуй өндөр байдаг. Иймээс үгийн сангийн утгазүйн талаас утгаар нь ангилал нь монгол хэлний үгийн сан зүйн бүрэлдэхүүн агуулга болох төдийгүй монгол хэлний цахим утгазүй (Mongolian Computational Semantics)-н суурь судалгаа болно. Монгол хэл бичгийн мэдээлэл боловсруулалтын материалын хөмрөг боловсруулах ба утгын толь байгуулах бодит хэрэгцээнд зориулж, тус өгүүлэлд утгын талбайн онолоор утгын ангиллын онолын загвар болгож, тэмдэг нэрийн үгийн сангийн үндсэн утгын онцлогийг үндэслэж, түүнийг 6 том төрөл, 262 жижиг төрөлд ангилж, тэдгээрийн харгалзсан тэмдгийн олонлогийг (mark set) боловсруулж, “Зуун түмэн үгтэй одоо үеийн монгол хэлний материалын хөмрөг”-т утгын тэмдэг хадсан байна. Мөн өгүүлэлд үгийн утгын ангиллын судлагдсан байдлыг тоймчлон тоочсон суурин дээр, утгын талбайн онол хийгээд тэмдэг нэрийн утгын ангилал, жич түүний тэмдгийн олонлогийг тайлбарлан өгүүлж, тус утгын ангиллын тогтолцооны материалын хөмрөг боловсруулах судалгааны хэрэглээний ач холбогдлыг хураангуйлан тайлбарлав.

**Түлхүүр үгс:** Монгол хэлний тэмдэг нэр, утгын ангилал, тэмдгийн тогтолцоо.

### **Нэг. Өмнөх судалгааны тойм байдал**

Монгол хэлэнд XIII зууны үеийн “Жеи-юан-и-юй”, “Хуа-и-и-юй” болон тэдгээрээс сүүлд гарсан XVI-XVIII зууны хоорондох бүтээлүүд болох “Хорин

нэгт тайлбар толь”, “Хорин наймт тайлбар толь” зэрэг тайлбар толь, орчуулгын тольд үгийн утгын ангилал ба тэдгээрийн харгалзсан жишээ үгсийг багтаасан юм. 1926 онд хэвлүүлсэн “Монгол утгын зүйл хуваасан толь бичиг” нь үгсийн хоорондох холбон хэрэглэгдэх байдалд суурилан утгаар нь ангилж байв. Сүүлийн үе, 1992 онд Д.Баатарын найруулсан “Иж үгийн толь” нь утгын талбайн онолд (the Theory of Semantic Field) суурилан хүмүүсийн найруулан бичихэд туслах зорилготой утгын зүйл хуваасан толь болно. Урт хугацааны турш, эдгээр толь бичиг дэх үгсийн утгын ангилал нь хэлний сургалт, найруулан бичихэд зориулсан гарын авлага байсан бөгөөд хүмүүсийн чухал хэрэгцээт номын нэг байсаар ирсэн юм. Монголын нэрт утга зүйч Д.Бадамдоржийн “Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс” (1997 он) бүтээл нь өнөөгийн утга зүйн онолын чухал агуулга болох утгын нэгжийн тухай судалсан бөгөөд утгалбар зэргийг зохих хэмжээгээр шинжилж, утга судлалыг хэлний бусад салбар ухаантай уялдуулан өвөрмөц онцлогийг нь тодруулсан юм. Түүний “Монгол хэлний утга судлал” (2001 он), “Монгол хэлний үгийн сангийн утга зүй” (2006 он) зэрэг бүтээлд монгол хэлний үгийн сан - утга зүйн ай, утгын орон мэт агуулгыг хамрахдаа “төрөл утгат үг” гэх нэр томъёог дурдсан нь тус судалгаан дахь “утгын ангилал”-тай шууд харгалзсан ухагдахуун болжээ. Тэрхүү бүтээлийн утгын ангиллын жишээ үг болон утгын төрлийн жагсаалтаас монгол хэлний үгсийн утгын ангиллын ерөнхий тогтолцооны загварын төлөв байдлыг олж харах мөртөө тэр нь шаталсан шинжтэй байхыг мэдэж болно. Үүний хамт, Б.Түргэн нарын “Орчин цагийн монгол хэлний судлал” (1988 он) нь үгийн утгын төрөл зүйл, утгын тогтолцоо, утгалбараар задлах аргыг, Хасартани нарын “Орчин цагийн монгол хэл” (1996 он)-д утгын талбай, утгалбар зэрэг агуулгыг хөндөн судалсан ажээ. Сэцэн, Дэлгэрмаа “Утга зүй” (1996 он), Дэлгэрмаа “Монгол хэлний утга судлал” (2001 он) бүтээлүүд нь утгын талбай, утгалбараар задлах аргыг системтэй танилцуулсан мөртөө орчин цагийн утга зүйн онол аргаар монгол хэлний утгын үзэгдлийг тайлбарлан түүний жам ёсыг илрүүлэхээр зорьсон юм. Өнгөрсний судалгаа нь үгийн утгын найрах харьцаа, утгын тогтолцоо зэрэг нэн гүн төвшний судлагдахуун тийш шилжсэн мөртөө утгын талбайн онолыг энэхүү өгүүлэлд үр дүнтэй ашиглахад арга зүйн лавлагаа болсон байна. Харин одоо үеийн монгол хэл зүйн ном зохиолд тэмдэг нэрийг утгын талаас нь тусгайлан судалсан нь харьцангуй цөөний дээр, тойм төдий ангилж, түүнээ хэл зүйн онцлог шинжийг илрүүлэхэд л тусламж төдий ашигладгаас, монгол хэл бичгийн мэдээлэл боловсруулалтын (Mongolian Information Processing) шаардлагыг хангаж, хэрэглээнд нэвтэртэл бас нэлээд зайтай байна. Ерөнхийдөө тэмдэг нэрийн ухагдахууныг томъёолохын тулд ямар ямар утгыг илтгэх үгс нь тэмдэг нэрд багтана гэж жишээлэн тайлбарладаг, энэ нь нэг ёсондоо тэмдэг нэрийн утгын талаарх товч ангилал болох юм. Тухайлбал, хүснэгт 1-д тэмдэг нэрийн утгыг монгол хэлний дөрвөн том бүтээлд хэрхэн ангилж байсныг харуулсан болно.

Монгол хэл зүйн бүтээл дэх тэмдэг нэрийн тухай ангиллын хураангуйлал  
Хүснэгт 1.

№	Зохиогч ба бүтээл	Тэмдэг нэрийн төрөл зүйл ба жишээ үгс
1.	Ш.Лувсанвандан “Орчин цагийн монгол хэл”	Өнгөний нэрс: хөх, улаан, цагаан, хар Чанарын нэрс: сайн, муу, шинэ, хуучин, хүнд, хөнгөн Хэмжээ байдлын нэрс: их, бага, өндөр, нам, урт, богино Овор байдлын нэрс: товгор, хотгор, хонхор, тэгш, хазгай
2.	Хамтын бүтээл “Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт”	Шинж чанар заасан: сайн, муу, сайхан, муухай, хүнд, хөнгөн, халуун, хүйтэн Өнгө заасан: улаан, ногоон, хар, шар, цагаан, цэнхэр, хүрэн, бор Хэлбэр хэмжээ заасан: урт, богино, өндөр, нам, бүдүүн, нарийн, хотгор, хавтгай Хөдөлгөөний янз байдал заасан: хурдан, удаан, аажуу, түргэн, шалмаг, гавшгай
3.	Өвөр монголын их сургууль “Одоо үеийн монгол хэл”	Өнгө зүсмийг заасан: улаан, ногоон, шар, хөх, хээр, хул Хэрэг юмны дотоод шинж чанарыг заасан: халуун, чанга, сул, залхуу, цэцэн, гашуун Хэрэг юмны гадар дүрс хэлбэр заасан: гурвалжин, хавтгай, хотгор, гүдгэр Хүмүүн амьтны бие махбодын байдлыг заасан: сохор, доголлон, эмсгэр, хялар Цаг орон зайн онцлогийг заасан: их, бага, урт, охор, хол, ойр Харьцааны онцлогийг заасан үг: морьт, уулан дахь, өнөөх
4.	Чингэлтэй “Одоо үеийн монгол хэлний зүй”	Хэрэг юмны шинж чанар, тоо хэмжээ болон дүр байдлыг заах үгс: сайн, муу, шинэ, хуучин, хүнд халуун Хүмүүний өвөрмөц шинж болон шинж тэмдгийг заах үгс: хөгшин, залуу, цэцэн, тэнэг, мариатай, тарган, туранхай Өнгө гэрэл ба зүсмийг заах үгс: улаан, хар, тунгалаг, бүдэг, тодорхой, хул, зээрд, халиун Өөр юмаар хэрэг юмны шинж чанарыг заах үүсмэл тэмдэг нэр: морьт, амтгүй, ухаантай, махлаг, ханьсаг, уулан дахь Үйл болон байдлын талаас хэрэг юмны шинж чанарыг тодорхойлдог үүсмэл тэмдэг нэр: зурмал, айтгай, ёсорхуу, үүлэрхүү, элсэрхүү “Авшгүй, хэлшгүй, үзэшгүй, ялагдашгүй, эвдэршгүй, мятаршгүй, эвлэршгүй” гэх мэт үгс

Эдгээр ангиллын нийт онцлог гэвэл, ангилал бүрийг тусгай төрөл болгон жагсаан цаашид улам нарийсган ангилах буюу утгын онцлогийг нь гүнзгий тодорхойлсон зүйлгүй тул тэр нь зөвхөн тэмдэг нэрийн хэл зүйн ангиллын нөхвөр төдий болсон юм. Тэмдэг нэрийг ерөнхийд нь ангилсан суурин дээр

тэмдэг нэрийн харьцуулах ай мэтийн хэл зүйн онцлог шинж, үүрэг чадамжийг системтэй тодорхойлохын төлөө ангилсан явц болох юм.

Байгаль хэлний шийдвэрлэлтийн үүднээс авч үзвэл утгын ангилал нь дээр дурдсан хэвлэмэл толь бичгүүдээс зөрөөтэй. Түүний гол онцлог нь компьютерт зориулсан байхад оршино. Өөрөөр хэлбэл, энд хэлж байгаа утгын ангилал гэдэг бол монгол хэлийг компьютерт таниулах ба ойлгуулахын тулд хэлний үгийн сангийн утгыг том төрлөөс жижиг төрөл тийш шаталсан шинжтэй нарийн тодорхой хуваахыг хэлнэ. Энэ чиглэлээрх судалгаанд, Эрдэнчулуу “Сураг занги шийдвэрлэлтэд зориулсан монгол хэлний үйл үгийн утга судлал” (2009 он), Жиан Ин Цүн “Сураг занги шийдвэрлэлтэд зориулсан монгол хэлний тэмдэг нэрийн утга судлал” (2003 он) зэрэг бүтээлийг нэрлэж болно. Дээрх бүтээлүүдэд тус бүр үйл үг, тэмдэг нэрийг байгаль хэлний шийдвэрлэлтийн талаас утгаар нь ангилан шинжилсэн юм. Ялангуяа Жиан Ин Цүнгийн бүтээл нь тус өгүүллийн сэдэвтэй нягт холбоотой бөгөөд энэхүү бүтээл нь монгол хэлний тэмдэг нэр болон жинхэнэ нэрийн утгын төрлийн уялдааг судлах үүднээс “Одоо үеийн монгол хэлний үгийн давтамжийн толь” дахь давтамжаар хамгийн өндөр болох 700 гаруй тэмдэг нэрийг сонгож, тэдгээрийг үндсэн утгаар нь ангилж, тэмдэг нэрийн утгын ангиллын анхны хэв загварыг гаргасан суурин дээрээ тэмдэг нэр ба жинхэнэ нэрийн уялдааг судалж, тэмдэг нэрийн захирагдахууныг (valence) тодорхойлохыг зорьсон юм. Энэхүү тэмдэг нэрийн утгын ангиллын загвар нь монгол хэл бичгийн мэдээлэл боловсруулалтын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ангилахыг оролдсон анхны оролдлого байсан учраас хожмын судлаачдад маш их үнэ цэнэтэй бүтээл болсон. Үүнээс гадна, Боо Жин Лан “Монгол хэлний хоршоо тэмдэг нэр ба жинхэнэ нэрийн утгын уялдааны тухай” (2005 он) өгүүлэл нь “Монгол хэлний хоршоо үгийн хөмрөг” дэх 700 гаруй хоршоо тэмдэг нэрээс үргэлж хэрэглэгдэх хоршоо чанар тэмдгийг сонгон утгаар нь ангилж, түүнтэй уялдах жинхэнэ нэрийг мөн утгаар нь ангилж, тодотгол тодотгуулагчийн харьцаа бүхий хоршоо тэмдэг нэр ба жинхэнэ нэрийн утгын уялдааг судалсан байна. Эд судалгааны дээрх судалгаанаас ялгаатай тал гэвэл, судлагдахуун ба судалгааны зорилго зорилт адил бусаас болж, адил бус ангиллын тогтолцоог гаргасанд оршино. Учир нь тус судалгааны судлагдахуун нь нийлмэл тэмдэг нэрийг хамарсан бол Жиан Ин Цүн судалгаагаар зөвхөн энгийн үгийн хүрээнд хийсэн юм.

Тэмдэг нэрийн утгын ангиллыг юунд ашиглах, ямар хүрээ хэмжээнд хэрэглэх зэрэг судалгааны адил бусын зорилгоос шалтгаалан, нэг тэмдэг нэрийг харилцан адилгүйгээр төрөлжүүлэн ангилдгаас ангиллын тогтолцоог өөр өөрөөр бүрдүүлдэг гэсэн дүгнэлтэд хүрч байна. Тэмдэг нэрийг утгаар нь ангилж буй бидний судалгааны бусад буюу өмнөх судалгаанаас ялгарах тал гэвэл, юуны өмнө ангилалд орох үг нь тэмдэг нэрийн энгийн үгийг багтаахаас биш, нийлмэл үг, хоршоо үг зэргийг багтаахгүй. Мөн түүнчлэн, тэмдэг нэрийн утгын тухай өмнөх судлаачдын ангилал нь харьцангуйгаар цөөн тооны тэмдэг нэрийг ангилж байсан бол энэхүү судалгаа нь их хэмжээний тэмдэг нэрийг утгаар нь ангилна. Тус өгүүлэл нь тэмдэг нэрийн утгын ангиллын өмнөх үеийн судалгаанд суурилж буй хэдий ч өнгөрсний ангиллаас илүү нарийн, тодорхойн

зэрэгцээ хөндлөнгийн логик харьцааны төрөл зүйл их, гулдаар шат давхарга нь олон, нягтралын хэмжээ нь өндөр байх ангиллын тогтолцоог боловсруулахаар судалж буй болно.

### **Хоёр. Утгын талбайн онол хийгээд тэмдэг нэрийн утгын ангилал**

Утга задлалтын олон онол аргуудын дотор утгын талбайн онол нь их өндөр байр эзэлнэ. Мэдээжээр, утгын талбай гэдэг бол ухагдахууны харьцаанд суурилсан үгсийн сангийн хоорондох хийсвэр утгын харьцааг илтгэнэ. Тухайлбал, ойролцоо буюу эсрэг харьцаа гэх мэт. Утгын талбай нь эл утгалсын харьцаа холбоо ба ялгаа зөрөөг илтгэж чадах бөгөөд утгын системч чанарыг харуулж чадна. “Утгын талбай” гэх энэхүү нэр томъёог 1924 онд Германы эрдэмтэн Г.Ипсэн (G.Ipsen) дурдсан байна. XX зууны гучаад оны үед Германы эрдэмтэн Ж.Триер (J.Trier) системтэй утгын талбайн онолыг дурдав. Гэвч XX зууны тавиад онд Чомский (Chomsky) хувиргал үүсгэл хэл зүйн онолыг гаргаснаар америкийн угсаатан зүйчээс утгалбараар задлах аргыг дурдах үеэр утгын талбайн онол нь сая л хүмүүсийн анхаарлыг татаж эхэлсэн юм. Хятад хэлээр жишээлбэл, Бээжин их сургуулийн профессор Жье Яан Де (贾彦德) “Хятад хэлний утга зүй” (1992 он) [2] гэх бүтээлдээ хятад хэлний утгын талбайн онолыг системчлэн дурдав. Бээжингийн хэлний их сургуулийн профессор Жан Пү (张普) өмнөх хүмүүсийн судалгаанд суурилж, байгаль хэлний шийдвэрлэлттэй уялдуулан “талбайн төрөл” (场类)-ын ухагдахууныг дурдаж, хятад хэлний утгын талбайн тухай судалгааг нэг алхам урагш түлхэн ахиулсан юм.

Өнгөрсөн зууны наяд оны үеэр, монгол хэлний утга судлалд утгын талбайн онолыг дурдаж өнгөрсөн бөгөөд мөн тус онолыг шууд утгын давхаргат харьцаатай холбогдуулан судалж байв. Ялангуяа “Утга зүй” [3] гэх номд, утгын талбайн шинж чанарын тухай “(Нэг) адил нэг утгын оронд харьяалагдах үгс нь нийтлэг утгын онцлогтой. (Хоёр) адил нэг утгын оронд харьяалагдах үгс нь хоорондоо утгын талаар харилцан холбоотой бөгөөд үг нэг бүрийн утга нь түүнтэй холбогдох эл үгсийн утгаар тодорхойлогдоно. (Гурав) утгын орон бол бүтцийн талаар давхаргаалаг шинж бүхий утгын дэс дараалалтай цугларал мөн. (Дөрөв) утгын орон нь үндэстний шинжтэй” хэмээн хураангуйлан тоочсон байна. Монгол улсын утга судлалд энэ тухай өвөрмөц хайлт хийсэн зүйлийг дурдууштай. Тухайлбал, өмнө өгүүлсэн Д.Бадамдорж “Монгол хэлний үгийн сангийн утга зүй” (2006 он) [4] бүтээл нь төрөл утгат үгийн шатлан харьцах утгын харьцааг үндэслэж, түүнийг (1) Тэнгэр мандал; (2) Шим ертөнц; (3) Сав ертөнц; (4) Хөдөлгөөн ертөнц гэмээн дөрвөн утгын орон болгон хувааж, цаашид мөн олон нарийн төрөлд ангилсан юм.

Тус судалгаа нь тэмдэг нэрийг утгаар нь системтэй ангилж, улмаар утгын төрлийн янз бүрийн онцлогийг нарийлаг хэлбэрчлэн тодорхойлж (Formalized Description), олон зүйлийн хэрэглээний системд үгсийн тус биеийн тогтонгуй онцлог (Static Feature)-ийн хэлбэрчилсэн мэдлэг шууд хангах бөгөөд хөдлөнгүй онцлог (Dynamic Feature)-ийн мэдлэгийг автоматаар олоход суурь болно.

Тэмдэг нэрийн утгын ангилал нь монгол хэлний үгсийн утгын ангиллын бүхий л тогтолцооны бүрэлдлийн суурь болохоор үл баран, бас монгол хэлний үгсийн утгын мэдлэгийн илтгэл (Knowledge Formulation) хийгээд үгсийн утгын тогтонгуй задлалт (Static Analysis)-ийн үндсэн мэдлэг болно. Монгол хэлний тэмдэг нэрийг утгаар нь ангилахад голдуу утгын талбайн онолыг ашиглан түүний харгалзсан ангиллын тогтолцоог гаргах болно.

Мөн чанараас нь үзвэл, утгын талбай бол үгийн утгаар бүрэлдсэн систем мөн. Тэр бол ухагдахуунд суурилсан харьцааны талбай байж, үгийн утга ба үгийн утгын хооронд бүрэлдсэн нэг зүйлийн бүрмөсөн хийсвэржсэн, бодосын бус орон зайн чанартай хүрээ цар болно [5]. Утгын талбайн бүрэлдүүн нэгж нь утгалаас болно. Үгийн утга нь ердөө утгын талбай дотор бусад үгийн утгатай харилцан үйлдэлцэх харьцаа үүсдэг юм. Хэд хэдэн утгаараа нягт холбоотой үг нь нэг ерөнхий нэрийдэлд харьяалагдвал утгын талбайг бүрдүүлдэг. Иймээс, утгын талбайн онол нь утгаар нь ангилсан толь бичгийн хөмрөг бүрдүүлэхэд тохиолдох онолын зарим асуудлыг шийдвэрлэх буюу тайлбарлахад чухал ач холбогдолтой. Байгаль хэлний шийдвэрлэлтэд зориулсан тэмдэг нэрийн утгын ангилал бол утгын талбайн онолоор үндэслэл болгосон, түүний үгсийн сангийн утгын илтгэсэн ухагдахууны төрөл зүйлд тулгуурласан ангилал болно.

Онолын хувьд, утгын талбайг үгсийн сангийн талбай (lexical field) ба холбохуй талбай (associative field) гэж хоёр төрөлд хувааж болно. Үгсийн сангийн талбай бол тогтонгуй байж, тэр нь үгийн утгын хоорондох бөөмнөрөх харьцаа (aggregation relationship)-аар дамжин илэрнэ. Холбохуй талбай бол хөдлөнгүй байж, тэр нь үгийн утгын хоорондох найрах харьцаа (combination relationship)-аар илэрч, голдуу утгын сүлжээтэй холбогдох учраас энд түүний тухай дэлгэрэнгүй бичихгүй. Жишээлбэл, “хүмүүний талбай: ажилчин, сурагч, цэрэг, сэхээтэн, багш, бичээч, дарга”, “өнгийн талбай: улаан, шар, ногоон, хөх, хар, цагаан”, “хир хэмжээний шинжийн талбай: өтгөн, шингэн, халуун, хүйтэн, хурдан, удаан, гүн, гүехэн, зузаан, нимгэн” зэрэг бол үгийн утгыг нь үндэслэн ангилсан үгсийн сангийн талбай болно. Хэрэглээний явцад, эдгээр утгын талбайг цаашид нарийсган нэн олон “бага талбай” буюу “жижиг талбай” болгон хувааж болохоор үл баран, бас тэдгээрийг хураангуйлан нэгтгээд “ерөнхий талбай” буюу “эх талбай” болгож болно. Үүнд адил бус төрөл хэлбэрийн утгын талбайг талбайн төрөл гэдэг.

Эл талбайн төрлийн хоорондоо эл зүйлийн утгын харьцаа үүсэж, олон төрлийн адил бусын утгын талбайг бүрдүүлж байдаг. Жишээлбэл, дундад улсын алдарт компьютер хэл шинжлэлтэн Фен Зи И Вви (冯志伟) утгын талбайг төрөл талбай, бүрэлдэхүүн талбай, дараалалт талбай, эсэргүүцэлтэл талбай хийгээд ижил утгат талбай гэж таван төрөлд ангилсан юм [6]. Тэмдэг нэрийн үгсийн аймгийн онцлогийг ажихад, чанар тэмдэг нэр нь тоо хэмжээний талаар бусад харьцаа тэмдэг нэр ба ялгах тэмдэг нэртэй харьцуулбал, харьцангуй өндөр хувийг эзэлж байх учраас тус судалгаанд утгаар нь ангилахад чанар тэмдэг нэрийн онцлог шинжийг голчлон харгалзсан билээ. Үүнд чанар тэмдэг нэр нь “Хэрэг юмны тус биед нь их бага адил бус хэмжээ оршиж байдаг шинж чанар ба бэлгэ тэмдэг, үйл хөдөлгөөний болох байдлыг заах” [7] бөгөөд ерөнхийдөө утгаараа



хэрэг бодис юмны шинж чанарыг илтгэж байдаг. Тэр мөртөө утгын талбайн онолд суурилбал, тэмдэг нэр нь олонхдоо бүр эсэргүүцэлдэх харьцаатай утгын талбайг бүрдүүлдэг. Учир нь “эсэргүүцэлтэл талбай”-гийн ижил байр дээрх үгийн утга нь эсрэг харьцаа илтгэнэ. Энэ нь тэмдэг нэрийн аймагт эсрэг утгатай үг олон байдаг онцлогтой нийцэж байдаг. Жишээлбэл, “хатуу” ба “зөөлөн”, “хүйтэн” ба “халуун”, “хурдан” ба “удаан” гэх мэт. Тэмдэг нэрийн энэ төрлийн эсэргүүцэлтэл нь шинж чанар, байдал төрх, үйл хөдөлгөөний чиглэл, үр дүн, орон байр, цаг зэрэг талын утгалбарын эсэргүүцлээр илэрнэ.

Өгүүлэлд, Өвөр монголын их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн боловсруулсан “Монгол хэлний утгын сураг зангийн толь” (2016 барлал)-аас 7000 гаруй тэмдэг нэрийг сонгож утгаар нь ангилах судлагдахуун болгосон юм. Энд тэмдэг нэрийн үгийн сангийн үндсэн утгыг үндэслэн, утгын талбайн онолд тулгуурлан, түүнийг анх алхам “бодосын шинж”, “хүмүүний шинж”, “адгуус амьтны шинж”, “орны шинж”, “цагийн шинж” ба “нийгмийн харьяат шинж” гэх 6 том талбай болгон ангилж, 262 жижиг талбайд хуваав. Үүний дагуу, Бүгд найрамдах дундад ард улсын стандарт болох “Сураг зангийн мэргэжил, сураг занги шийдвэрлэлтэд зориулсан монгол хэлний үгсийн тэмдэг” [8] тогтоосон арга туршлагад суурилан, тэмдэг нэрийн утгыг автоматаар шийдвэрлэх ба хүний хүчээр тэмдэг хадахад нэгдэлтэй үндэслэл, стандарт хангах зорилгоос үүдэн, тэмдэг нэрийн утгын ангиллын тогтолцоо ба түүнтэй харгалзсан тэмдгийн олонлогийг боловсруулсан байна.

### **Гурав. Тэмдэг нэрийн утгын ангиллын тогтолцоо хийгээд тэмдгийн олонлог**

#### **1. Тэмдэг нэр (A)**

##### **1.1. Бодосын шинж (Ab)**

##### **1.1.1 хэр хэмжээний шинж (Abx)**

##### **1.1.11 өтгөц (Abxo)**

1.1.111 өтгөн (Abxo1): өтгөн, агшуун, агшуувтар, анхилуун

1.1.112 шингэн (Abxo2): шингэн, шингэвтэр, шингэлэг, шингэвэр

##### **1.1.12 дулааны хэмжээ (Abxd)**

1.1.121 халуун (Abxd1): лүгхийм, илчигнэм, бүгчим, шатам, аагим

1.1.122 хүйтэн (Abxd2): жихүүн, жингэнэм, хөлдүү, тасхийм, хахир

1.1.123 дулаан (Abxd3): дулаан, дулаахан, урин, урьхан, бүлээн

1.1.124 сэрүүн (Abxd4): сэрүүн, сэрүүхэн, сэрүүвтэр

##### **1.1.13 хурдац (Abxh)**

1.1.131 хурдан (Abxh1): түргэн, бушуу, гавшгай, шаламгай, үтэр

1.1.132 удаан (Abxh2): аажуу, аажим, алгуур, алгуурхан, зөөнгөдүү

##### **1.1.14 уртац (Abxv)**

1.1.141 урт (Abxv1): урт, уртавтар, урлаг, сунжуун, шомбон

1.1.142 охор (Abxv2): ахар, ахархан, оготор, дэгдгэр, оодон

##### **1.1.1.5 өндөрц (Abxu)**

1.1.1.51 өндөр (Abxu1): өндөр, өндөрхөн, горгор

1.1.1.52 богино (Abxu2): богинохон, богинодуу, нам, намхан, тогдгор

- 1.1.1.6 өргөц (Abxr)
- 1.1.1.61 өргөн (Abxr1): өргөлөг, өргөвтөр, халбагар, нэлгэр, хүлхгэр
- 1.1.1.62 явцуу (Abxr2): авчуу, бачим, уйтан, давчуу, цухал
- 1.1.1.7 гүнц (Abxg)
- 1.1.1.71 гүн (Abxg1): гүн, гүнзгий, гүнзгийвтэр, гүнзгийхэн
- 1.1.1.72 гүехэн (Abxg2): цүнхгэр, гүевэр, гүехэн, гүйн, танган
- 1.1.1.8 нягтац (Abxn)
- 1.1.1.81 нягт (Abxn1): шигүү, баглиун, ягч, нягт, ширх
- 1.1.1.82 сийрэг (Abxn2): сайрмаг, сийрэгдүү, армаг, архай, сиймхий
- 1.1.1.9 зузааны хэмжээ (Abxj)
- 1.1.1.91 зузаан (Abxj1): зузаан, зузаалаг, зузаандуу, хяхнам
- 1.1.1.92 нимгэн (Abxj2): сармигар, нимгэхэн, нимгэндүү, саримдаг
- 1.1.1.A хатууц (Abxx)
- 1.1.1.A1 хатуу (Abxx1): хатуулаг, яслаг, хөр, горзгор
- 1.1.1.A2 зөөлөн (Abxx2): булбарай, уян, нэмүүн, үйрэм, хүүрэглэг
- 1.1.1.B хуурай нойтон(Abxt)
- 1.1.1.B1 хуурай (Abxt1): аглиун, хагсмал, эгшүүн, агируун, гандуун
- 1.1.1.B2 нойтон (Abxt2): чийглэг, нойтовтор, шүүдэнгэ, урилган
- 1.1.1.C бүдүүн нарийн (Abxb)
- 1.1.1.C1 бүдүүн (Abxb1): хадуун, бүдүүн, нидүүн, хүдэр
- 1.1.1.C2 нарийн (Abxb2): нарийхан, нарийлаг, шидмэг, гожгор, зэрэмгэр
- 1.1.1.D чанга сул (Abxc)
- 1.1.1.D1 чанга (Abxc1): чанаг, бариу, чангалаг, чагтуун, бариухан
- 1.1.1.D2 сул (Abxc2): үлжгэр, сулавтар, холхио, холхиндог, хонгилдог
- 1.1.1.E их бага (Abxu)
- 1.1.1.E1 их (Abxu1): том, мундаг, аварга, агуу, аугаа
- 1.1.1.E2 бага (Abxu2): багавтар, бяцхан, жижиг, жаахан, бичил
- 1.1.1.F үнэтэй хямд (Abxd)
- 1.1.1.F1 үнэтэй (Abxd1): үнэтэй
- 1.1.1.F2 хямд (Abxd2): хямд, хямдхан
- 1.1.1.G олон цөөн (Abxl)
- 1.1.1.G1 олон (Abxl1): элбэг, гүйцэд, баялаг, олон, дэлбэг
- 1.1.1.G2 цөөн (Abxl2): цөөвтөр, хомс, ховор, чухаг, өчүүхэн
- 1.1.1.H илүү дутуу (Abxi)
- 1.1.1.H1 илүү (Abxi1): илүүхэн, илүүц
- 1.1.1.H2 дутуу (Abxi2): дулимаг, дурган, хомсхон, дутмаг, мөчид
- 1.1.1.I харьцал (Abxc): зонхилох, ихэнх, олонх, зөндөө, заримдаг
- 1.1.1.J хүнд хөнгөн (Abxw)
- 1.1.1.J1 хүнд (Abxw1): хүндхэн, нүсэр, чавхай, чамбай, чихмай
- 1.1.1.J2 хөнгөн(Abxw2): хөнгөхөн, хөнгөндүү, хөнгөвтөр, хөнгөн
- 1.1.1.K цэвэр бузар (Abxa)
- 1.1.1.K1 цэвэр (Abxa1): ариун, цэвэрхэн, цэмбэгэр, шижир, цэмцгэр
- 1.1.1.K2 бузар (Abxa2): халтан, бурзантай, бохир, новширхог, хиртэй
- 1.1.1.L бүхэл бүтэн (Abxt)



- 1.1.1.L1 бүрэн бүтэн (Abxt1): бүхэл, бүхий л, төгөлдөр, цул
- 1.1.1.L2 эмтэрхий эвдэрхий (Abxt2): хэлтэрхий, хэмхэрхий, хэгзэрхий, уранхай
- 1.1.1.M болсон түүхий (Abxs): шүүрмэг, түүхий, болцуун, шүүрхий
- 1.1.1.N хурц мохоо (Abxm)
- 1.1.1.N1 хурц (Abxm1): даамтгай, шөвгөр, шовх, жомбогор, иртэй
- 1.1.1.N2 мохоо (Abxm2): мулгар, мохдог, мухар, мойног, майрдаг
- 1.1.1.O шинэ хуучин (Abxs)
- 1.1.1.O1 шинэ (Abxs1: шинэ, шинэхэн, шинэвтэр
- 1.1.1.O2 хуучин (Abxs2: хуучирхаг, хуучивтар, зүгээрхэн
- 1.1.2 балархай шинж (Abb)
- 1.1.2.1 сэрлийн шинж (Abbs)
- 1.1.2.11 харааны сэрэл (Abbsx)
- 1.1.2.111 гэгээн (Abbsx1): гэгээн, тодорхой, саруул, гэрэлт, дурайм
- 1.1.2.112 бүдэг (Abbsx2): балархай, бүрэг, бүрэнгүй, бүртэн
- 1.1.2.12 хүрэлцэх сэрэл (Abbh): арзгар, гөлгөр, гилгэр, нялцгар, барсгар
- 1.1.2.13 сонорын сэрэл (Abbs): яруу, хүнгэнэм, цээлхэн, уянгатай, эгшиглэг
- 1.1.2.14 амтны сэрэл (Abbsa)
- 1.1.2.141 исгэлэн (Abbsa1): исгэлэн, хүчиллэг, айраглаг
- 1.1.2.142 чихэрлэг (Abbsa2): чихэрлэг, заваан, хэншигхэн, хахруун
- 1.1.2.143 гашуун (Abbsa3): гашуувтар, гасан, заваан, эхүүн, нясуун
- 1.1.2.144 давслаг (Abbsa4): давсархуу, давсархаг, шорлог, шортой, шорвог
- 1.1.2.145 бусад амт (Abbsa5): шандуун, сулбагар, амттайхан, амттай, амтлаг
- 1.1.2.15 үнэрийн сэрэл (Abbsu)
- 1.1.2.151 ханхлам (Abbsu1): нилэг, санхилуун, санхилам, анхилам, анхилмал
- 1.1.2.152 өмхий (Abbsu2): хахуун, хэншүүн, хуншуун, хуршмал
- 1.1.2.2 чанар чансаа (Abbc)
- 1.1.2.1 шилдэг (Abbc1): дориун, гавьтай, олигтой, сайтай, чанарлаг
- 1.1.2.2 аанай (Abbc2): жавуун, барагтай, муу, аанайхан, муухай
- 1.1.2.3 өн шимлэг (Abbm): шимэрхэг, шимэрхүү, шимлэг, шимлэгхэн
- 1.1.2.4 онц ерөмдөг (Abbo)
- 1.1.2.41 онц (Abbo1): онцгой, өвөрмөц, асдаан, ондоошмол
- 1.1.2.42 ерөмдөг (Abbo2): түгээмэл, нийтлэг, ерөнхий, жир
- 1.1.2.5 янз хэлбэр (Abby)
- 1.1.2.51 дүгрэг (Abby1): дугариг, бөмлөг, бөмбөөхий, бондгор, дугуй
- 1.1.2.52 урталжин (Abby2): жишүүлжин, урталжин
- 1.1.2.53 гурвалжин (Abby3): гурвалжин, хошуулжин
- 1.1.2.54 дөрвөлжин (Abby4): дөрвөлжин, дөрвөлж, тэвхэр, тэвхгэр
- 1.1.2.55 зуувандуу (Abby5): өндөглөг, өндгөлжин, зуувгар, зуувгархан, зууванцар
- 1.1.2.56 тоонолжин (Abby6): тоонолжин, тоонолжин
- 1.1.2.57 зургаалжин (Abby7): зургаалжин, наймалжин, тавалжин, шоролжин
- 1.1.2.58 нуманцар (Abby8): цүзгэр, мөөрөлжин, муруйлжин, мядгар, мөөрөн
- 1.1.2.59 бусад хэлбэр (Abby9): битүү, задгай, дэвүүрлэг, гонзгой, хуниастай

- 1.1.3 өнгө (Abu): улаан, улбар, шар, хөх, ногоон
- 1.1.4 оршихуй (Abo)
- 1.1.4.1 тогтонги хөдлөнгүй (Abot)
- 1.1.4.11 тогтонги (Abot1): тогтмол, бахи, байртай, тогтонги, хэлбэржүүн
- 1.1.4.12 хөдлөнгүй (Abot2): хөдлөнгө, урсанги, урсам, шивнүүр
- 1.1.4.2 эмх замбараа (Aboe)
- 1.1.4.21 цэгцтэй (Aboe1): цомхон, эмхт, цэгцхэн, жигд, дэгтэй
- 1.1.4.22 замбараагүй (Aboe2): хөглөрхий, новширхуу, сандархай, ловширхог
- 1.1.5 цаг агаар (Abc)
- 1.1.51 тунгалаг (Abc1): нартай, тунарам, нарлаг, наруул, цэлмэг
- 1.1.52 бүрхэг (Abc2): үүлтэй, үүлэрхэг, будангуй, баргар
- 1.1.53 салхи бороотой (Abc3): хуртай, салхитай, шуургатай, элстэй, жавартай
- 1.1.6 үйлдэл хэрэгцээ (Abh)
- 1.1.61 хэрэгцээтэй (Abh1): ашигтай, ашигт, найдвартай, ачтай, чухал
- 1.1.61 хортой (Abh2): хорт, хорт, хөнөөлт
- 1.2 Хүмүүний шинж (Ah)**
- 1.2.1 нас жил (Ahn)
- 1.2.11 нялх бага (Ahn1): нялх, нялзрай, нярай, балчир, жаал
- 1.2.12 идэр залуу (Ahn2): залуу, идэр, идэрхэн, орь
- 1.2.13 өтлөө настай (Ahn3): настай, өвгөжөөр, хөгшин, ахимаг, насжуу
- 1.2.14 бусад (Ahn4): отгон, ууган
- 1.2.2 зан үйл (Ahj)
- 1.2.21 номхон бардам (Ahj1)
- 1.2.211 номхон (Ahj11): даруу, усгал, номой, дөлгөөн, хөнгөмсөг
- 1.2.212 бардам (Ahj12): оморхог, огсгор, омуун, харгис, дээрэнгүй
- 1.2.22 үнэнч худалч (Ahj2)
- 1.2.221 үнэнч (Ahj21): цэгц, асвар, цайлган, шударга, голч
- 1.2.222 хуурамч (Ahj22): хулжин, хуйхар, худалч, бялдууч, ховч
- 1.2.23 эрэлхэг аймтгай (Ahj3)
- 1.2.231 эрэлхэг (Ahj31): баатарлаг, хүчирхэг, хатан, эрэмгий, зоригтой
- 1.2.232 аймтгай (Ahj32): үхээнц, балмаг, уйлхай, бишүүрэмтгий, сүрдэмхий
- 1.2.24 эрс эргэлзэлтэй (Ahj4)
- 1.2.241 тасархай (Ahj41): эрс, шуурхай, шуудангуй, шийдэмгий, зоримтгой
- 1.2.241 эргэлзэлтэй (Ahj42): шавхаа, яламгай, ичимхий, гирвэ, ширвээлэг
- 1.2.25 ажилч алжуу (Ahj5)
- 1.2.251 ажилч (Ahj51): ажилсаг, хатуужилтай, шаргуу, хөдөлмөрч, зүтгэмтгий
- 1.2.252 алжуу (Ahj52): залхуу, хойрго, хашин, хашивтар, дөжир
- 1.2.26 арвич бүрэлгэмтгий (Ahj6)
- 1.2.261 арвич (Ahj61): арвич, гамтай
- 1.2.262 бүрэлгэмтгий (Ahj62): бүрэлгээч, бармал, савуур, гаатай<sup>[SEP]</sup>1.2.27
- харамч өгөөмөрч (Ahj7)
- 1.2.271 харамч (Ahj71): хувинцар, харуу, яхир, хявцаг, аминцар

- 1.2.272 өгөөмөрч (Ahj72): өгөөмөр, уудамч, уучламтгай, өглөгч  
 1.2.28 уяхан зөрүү (Ahj8)  
 1.2.281 уяхан (Ahj81): эедүү, эелсэг, дотносог, ээлтэй, элэгсэг  
 1.2.281 зөрүү (Ahj82): мужууд, бурангуй, гөжүүн, зөрүүд, зожиг  
 1.2.29 лавдуун хуумгай (Ahj9)  
 1.2.291 лавдуун (Ahj91): хэрсүү, болгоомжтой, хянамгай, нямбай, хичээнгүй  
 1.2.292 хуумгай (Ahj92): хөөрүү, цүлт, гэнэн, дэврүү, онгиороо  
 1.2.2A идэвхтэй наазгай (AhjA)  
 1.2.2A1 идэвхтэй (AhjA1): давшимгай, шамдамтгай, санаачилгатай, хүсүүрхэг  
 1.2.2A2 наазгай (AhjA2): наазгай, гутрангуй, гуниглангуй, гутармал  
 1.2.2B гоёломтгой (AhjB): ганган, хээмсэг, гоёрхог, гийгэнцэр, цэмцгэр  
 1.2.2C мартамтгай (AhjC): мартамхай, мартамтгай, умартамтгай, мартанхай  
 1.2.2D хэлэмтгий (AhjD): аманцар, завшуур, доншоо, нуршаа, нуншаа  
 1.2.2F атаархаг (AhjF): атаач, атаархуу, үтээрхүү, атаархаач, атаатай  
 1.2.2E эрх танхи (AhjE): танхилзуур, найланхайдуу, эрхэгтэй, эрхэмсэг, эмсэг  
 1.2.2G самуун зайдан (AhjG): садар, айданга, шалиун, завхай, танхай  
 1.2.2H ховдог шунахай (AhjH): идэмхий, олбин, хоолонцор, залгидаг, шунахай  
 1.2.3 оюун ухаан (Ahv)  
 1.2.31 сэргэлэн бядуу (Ahvs)  
 1.2.311 сэргэлэн (Ahvs1): хурц, цэцэн, сэргэг, мэргэн, сэргий  
 1.2.312 бядуу (Ahvs2): мунхаг, зөнөг, нозоон, балай, мунаг, эргүү  
 1.2.32 авьяас чадвартай (Ahva): гарамгай, бүтээлч, мэргэжилтэй, авьяаслаг, чадамгай  
 1.2.4 сэтгэлийн хөдөлгөөн (Ahs)  
 1.2.41 баясангуй гутрангуй (Ahsb)  
 1.2.411 баясангуй (Ahsb1): баясгалант, баяртай, баярлангуй, баясам, мишээнгүй  
 1.2.422 гутрангуй (Ahsb2): гунигт, эмгэнэлт, зовлонт, гаслант, зовнингуй  
 1.2.42 таашаал зэвүүцэл (Ahst)  
 1.2.421 таашаал (Ahst1): тавтай, хавтай, ханамжтай, тохилог, аятай  
 1.2.422 зэвүүцэл (Ahst2): эгдүүтэй, жигшүүртэй, ярвагай, ярвагар  
 1.2.43 аймаар цочоомоор (Ahst3): аюулт, цочоом, аймшигтай, түгшүүртэй, хулчгар  
 1.2.5 ахуй байдал (Aha)  
 1.2.51 баян ядуу (Aha1)  
 1.2.511 баян (Aha11): баян, баялаг, чинээлэг  
 1.2.512 ядуу (Aha12): үгээгүү, ядмаг, ядуулаг, яданги, зүдүү  
 1.2.52 зүдрэнгүй (Ahbb2): ядрангуй, зүдэнгэ, алжаангуй, ядруу, зүдрэлтэй  
 1.2.53 бээрэнхий (Ahbb3): бэрвэгэр, бээрэг, бээрэмтгий, давжигнуур, бээрэнхий  
 1.2.6 дүр төрх (Ahd)

- 1.2.61 өнгө зүс (Ahdo)
- 1.2.611 гоё (Ahdo11): гоо, гуалаг, үзэсгэлэн, ганган, царайлаг
- 1.2.612 муухай (Ahdo12): муухайвтар, муухай, хөдөөвөр, борог
- 1.2.62 бие галбир (Ahdb)
- 1.2.621 тарган (Ahdb1): луглагар, махлаг, мариалаг, палдгар, ёлхгор
- 1.2.622 эцэнхий (Ahdb2): туранхай, хатангир, янгир, енхгөр, данхигар
- 1.2.623 нарийн өндөр (Ahdb3): нахилзам, дэнхгэр, сунагар, нуруулаг, гойзон
- 1.2.624 ханагар бүдүүн (Ahdb4): хэнхгэр, дэндгэр, ханхигар, бадриун
- 1.2.625 одой пагдгар (Ahdb5): тагдга, тагжгар, тагдгар, агзгар, язгар
- 1.2.63 эрхтэн (Ahde)
- 1.2.631 нүд (Ahde1)
- 1.2.6311 харц (Ahde11): гярхай, сөлөр, олигор, солир, зэмлэнгүй
- 1.2.6312 янз хэлбэр (Ahde12): анигар, дүрэлгэр, бүлтгэр, зэртгэр, торомгор
- 1.2.6313 гэм архаг (Ahde13): сохор, харалган, харанга, улцран, цавчраа
- 1.2.632 хамар (Ahde2): шөнтгөр, шантгар, сартаг, монхгор, марлигар
- 1.2.633 магнай (Ahde3): мэтгэр, мэлзэн
- 1.2.634 уруул ам (Ahde4): дорвогор, эмшгэр, ярвагар, умгар, цөрвөгөр
- 1.2.635 шүд (Ahde5): майга, эмтгэр, ярзгар
- 1.2.636 чих (Ahde6): дэлдэн, дэлдгэр, навтгар
- 1.2.637 хүзүү чээж (Ahde7): хагдгар, нүгдгэр, хагдгар, мэгжгэр, хөдгөр
- 1.2.638 толгой (Ahde8): хоовгор, зантгар, манхгар, хөдгөр, хөнхгөрхөн
- 1.2.639 үс гээг (Ahde9): молтог, халзан, азар, зэнтгэр, агшуун
- 1.2.63A нүүр царай (AhdeA)
- 1.2.63A1 царайн төлөв (AhdeA1): бумбагар, бондгор, мантгар, цулцан, хонхигор
- 1.2.63A2 царайн өнгө (AhdeA2): зэвхий, хужин, цонхигор, чилдгэр, хулчин
- 1.2.63B гэдэс (AhdeB): түсгэгэр, цодгор, түжгэр, цэдгэр, цэрдгэр
- 1.2.63C нуруу (AhdeC): бэгцгэр, түгдгэр, түгдгэр, бэхгэр, мэхгэр
- 1.2.63D хөл (AhdeD): алцгар, тайвгар, шойшиг, майтгар, доголон
- 1.2.63E архаг гэм (AhdeE): архагтай, эрэмдэг, гэмт, хавдартай, зэмдэг
- 1.2.7 танихуйн шинж (Aht)
- 1.2.71 зөв буруу (Aht1): оновчтой, гажуу, халуу, ташаа, андуу
- 1.2.72 жинхэнэ хуурмаг (Aht2): үнэн, худалч, худал, хуурмаг, худалд
- 1.2.73 хүчир хялбар (Aht3): бэрх, хүчир, түвэгтэй, будлиантай, амар, дөхөм
- 1.2.74 бодитой хийсвэр (Aht4): бодитой, бодит, хийсвэр, ерөнхий, бүдүүвч
- 1.2.75 тодорхой балархай (Aht5): илэрхий, илт, товойм, бүдэг, гүнзгий
- 1.2.76 биеч бусдач (Aht6): биеч, бусдач, бодисч, сэтгэлч
- 1.2.8 нийгмийн харьяат шинж (Ahx)
- 1.2.81 соёл боловсрол (Ahx1): боловсон, ёсорхог, болхи, бүдүүлэг
- 1.2.82 байр суурь (Ahx2): алдарт, нэртэй, нэрт, цуутай, цуут
- 1.2.83 биеийн гарал (Ahx3): харц, өнчин, тэнүүл, бэлбэсэн
- 1.2.84 ураг хурим (Ahx4): сүйтэй, урагтай, ураглаатай
- 1.2.85 хүмүүний харьцаа (Ahx5): дотно, ойр, дотносог, халуумсаг, зочинсог

### 1.3 Адгуус амьтны шинж (Aa)

- 1.31 нас (Aan): шүдлэн, гунжин, гунан, хязаалан, соёолон
- 1.32 зүсэм (Aaj): алаг, хүрэн, хул, хонгор, халиун, борогч
- 1.33 араншин (Aaa): ардаг, эмнэг, ороо, натгамтгай, үргэдэг
- 1.34 галбир төрх (Aag): говор, боргил, богсгор, бэсрэгхэн, бадгар
- 1.35 явдал (Aay): боншоо, давхиа, доншоо, тэлмэн, шогшим, хатираатай

### 1.4 Орны шинж (Ao)

- 1.4.1 шулуун (Aos)
- 1.4.11 зай (Aos1): хол, ойр, ойролцоо, алс, дөт
- 1.4.12 байр (Aos2): доод, тэртээх, хойшхон, хажуудхан, солгой
- 1.4.13 чиглэл (Aos3): хөндлөн, гулд, гозон, гозойлдон, жайвгар
- 1.4.2 хавтгай (Aoh)
- 1.4.21 тэгш (Aoh1): тэгшхэн, шулуун, асхан, толигор, жалбигар
- 1.4.22 налуу (Aoh2): жишүү, хариу, хэлбийгүү, ташуу, хазгай
- 1.4.3 огторгуй (Aoo)
- 1.4.31 дүүрэн (Aoo1): дүүрхэн, халгим, бялхам, мэлэлзэм, илэм
- 1.4.32 уудам (Aoo2): хангай, уужим, цэлгэр, ээрэм, дардан

### 1.5 Цагийн шинж (Ac)

- 1.5.1 бачим сэлүү (Acb)
- 1.5.11 бачим (Acb1): тулгам, тулгамдуу, шавдуу, бачим, бачимдуу
- 1.5.12 сэлүү (Acb2): сэлүү, завдуу
- 1.5.2 хам цуваа (Ach)
- 1.5.21 хам цаг (Ach1): анхдагч, түрүүч, дараач, сүүлч, түр
- 1.5.22 цуваа цаг (Ach2): одоох, түүхт, хойч, узуур, мөнх

### 1.6 нийгмийн харьяат шинж (An)

- 1.6.1 нийгмийн байгуулал (Anb): хамжилгат, хөрөнгөт, хаант, боолчлолт, боолт
- 1.6.2 амар төвшин (Ana): тогтуун, тогтонгуй, тогтнуун, самуун, эсэн
- 1.6.3 хөгжилтийн байдал (Anh): бадруун, бадрангуй, дэвжүүн, буурангуй, эсрэг

Тэмдэг нэрийн утгын ангиллын хэрэглээний шинж ба бүхий л тогтолцооны бүрхэцийн хэмжээг туршихын тулд, судалгааны дүнд Өвөр монголын их сургуулийн боловсруулсан “Зуун түмэн үгтэй одоо үеийн монгол хэлний материалын хөмрөг”-аас 5000 өгүүлбэрийг тохиолдлын(randomly) шинжтэй сонгож, өмнө жагсаасан утгын төрлийн мэдээллийн тэмдэг хадсан байна. Тухайлбал, хүн машин харилцан оролцох хэлбэрээр Mglex тэмдэг хадах систем, утгын тэмдэг хадах дүрмийг харилцан уялдуулах хэлбэрээр материалын хөмрөгт тэмдэг хадаж, хамгийн сүүлд хүний хүчээр нягтлан шалгаж, 5000 өгүүлбэрийн утгын тэмдэг хадсан боловсронгуй материалын хөмрөг байгуулж байна. Жишээлбэл: “SARAGVL/Ac(Abbsx1) AGVDAM/Ac(Abbsx1) TAL\_A/Ne2(Nh\$(Nbhy3)@ NVTVG/Ne1(N0b21)-TV/Fc21(Nob1)@ MINI/Sf NAGVR/Ne1(Nbbu13)@ TANGGIS/Ne1(Nbbu13) T0G\_A/Ne2 UGEI/Su 0LAN/Ac(Abx11) BAI/Ve2+DAG/Ft21 B0LBACV/Cr EYIMU/Rj SAYIHAN/

Ac(Ahdo11) HALAGVN/Ac(Abxdl) D0T0N0/Ac(Ahj81) NER\_E/Ne1 TEI/Sb NAGVR/Ne1(Nbbu13)@ OGER\_E/Ri BASA/Sc BAI/Ve2+N\_A/Fs21 GE/Vx+JI/Fs12(VHOILYA)@ UU/Sa ?/Wp1” (Үүнд жишүү зураас\-гийн ар дахь Ac тэмдэг нь монгол хэлний тэмдэг нэрийн үгсийн аймаг ба үг зүйн хувиллын тэмдэг бөгөөд түүний арын хаалт () доторх нь тэмдэг нэрийн утгын төрлийн тэмдэг юм). Энэ нь тэмдэг нэрийн утгын ангиллын тэмдгийн олонлогийг тасралтгүй төгөлдөржүүлж сайжруулах анхан шатны бодит туршилт болно.

### Зүүлт

[1] Ш.Лувсанвандан “Орчин цагийн монгол хэл”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо., 1961 он.

[2] Хамтын бүтээл “Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт”, тэргүүн дэвтэр. Улаанбаатар., 1987 он.

[3] Өвөр монголын их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн монгол хэл бичиг судлах газар “Одоо үеийн монгол хэл” (хоёрдугаар хэвлэл)., 2005 он.

[4] Чингэлтэй “Одоо үеийн монгол хэлний зүй”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо., 1979 он.

[5] Эрдэнчулуу “Сураг занги шийдвэрлэлтэд зориулсан монгол хэлний үйл үгийн утга судлал”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо., 2009 он.

[6] Жиан Ин Цүн “Сураг занги шийдвэрлэлтэд зориулсан монгол хэлний тэмдэг нэрийн утга судлал”, Өвөр монголын их сургуулийн мастер цол хамгаалах өгүүлэл., 2003 он.

[7] Боо Жин Лан “Монгол хэлний хоршоо тэмдэг нэр ба жинхэнэ нэрийн утгын уялдааны тухай”, Өвөр монголын багшийн их сургуулийн мастер цол хамгаалах өгүүлэл., 2005 он.

[8] Сэцэн., Дэлгэрмаа “Утга зүй”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо., 1996 он.

[9] Д.Бадамдорж “Монгол хэлний үгийн сангийн утга зүй”, Улаанбаатар хот., 2006 он, х.221.

[10][11]冯志伟著, “自然语言计算机形式分析的理论与方法”, 中国科学技术大学出版社2017. 1月, p. 418-421.

[12] Өвөр монголын их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн Монгол хэл бичиг судлах газар “Одоо үеийн монгол хэл” (хоёрдугаар хэвлэл)., 2005 он, х.415.

[13] Бүгд найрамдах дундад ард улсын стандарт “Сураг зангийн мэргэжил, сураг занги шийдвэрлэлтэд зориулсан монгол хэлний үгсийн тэмдэг” (GBT 26235-2010), Бүгд найрамдах дундад ард улсын улсын чанар чансааг хянан батлах ерөнхий товчоо, дундад улсын улсын стандартын хамааралтын зөвлөл., 2011 оны 11 сар.